# 2015 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Ужимхангай ХК нь 2015 онд үндсэн үйл ажиллагаагаа явуулаагүй. Харин компанийг дахин хөрөнгөжүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны зогсонги байдлаас гарахын тулд хөдөө аж ахуйн салбарт ажилладаг, үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилж буй Стандарт агрикалчер групп ХХК-ийг нэгтгэж, компанийг өөрчлөн байгуулах ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Компанийн үнэт цаасны арилжааг сэргээх ажлыг 2015 оны 5-р сараас эхлүүлж Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргаснаар СЗХ нь 2015 оны 9-р сарын 25 өдрийн 368 дугаар тогтоолоор MSE:SOH хувьцааны арилжааг 2008 оноос түр зогсоосон байсныг сэргээсэн.
- Улмаар Стандарт агрикалчер групп ХХК-ийг нэгтгэх ажиллагааг 2015 оны 10-р сараас эхлүүлж, 12-р сарын 10-ны өдөр СЗХ-д хууль, журмын дагуу шаардлагатай материалуудыг бүрдүүлж хүргэсэн. Үүнд дараах ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн:
    - 2015 оны 3-р улирлын санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллага болох Си Эс Ай Аудит ХХК-тай гэрээ байгуулж баталгаажуулсан.
    - Аудитлагдсан санхүүгийн тайлангуудад үндэслэн, Стандарт агрикалчер групп ХХК-д хөрвүүлэн эзэмшүүлэх хувьцааны тооцоолол, харьцааг гаргаж компани нэгтгэх гэрээ, журмыг 2015 оны 10-р сарын 29-ний өдөр байгуулж баталсан.
    - Компани өөрчлөн байгуулах комиссыг 2015 оны 10-р сарын 29-нд байгуулсан.
    - Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай танилцуулгыг мэргэжлийн андеррайтерийн байгууллага болох Стандарт инвестмент ҮЦК-тай гэрээ байгуулан боловсруулуулсан.
    - Компани нэгтгэх үйл явцад хуулийн дүгнэлт гаргуулахаар Өмгөөллийн Монгол зарга ХХН-тэй гэрээ байгуулан ажилласан.
    - Стандарт агрикалчер групп ХХК-ийн хөндлөнгийн үнэлгээчнээр хийлгэсэн хөрөнгийн үнэлгээтэй танилцсан.
    - 2016 оны 2-р сард СЗХ-ноос шаардсан нэмэлт материалуудыг бүрдүүлж, хүргүүлүүлсэн.

Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүн Б.Үндрал гадаад руу урт хугацаагаар явсан тул Б.Энхжаргалыг түр гишүүнээр 2015 оны 11-р сард томилсон. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос 2015 оны жилийн эцсийн тайлант аудитлуулахаар Фискал аудит ХХК-ийг сонгосон.